



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/548

Хэрлэн сум

Талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авахад ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Газрын хэвлийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2.1 дэх заалтууд, Засгийн газрын 2014 оны "Журам батлах тухай" 222 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хийгдэж буй дэд бүтцийн ажлуудын нөлөөгөөр эвдрэлд орсон талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авахад ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
дарга:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Нарийн бичгийн
дарга:

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газрын хэвлий,
нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн

Тухайн сумын Засаг дарга


Тухайн сумын Татварын байцаагч

Тухайн сумын Газрын даамал

Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

2. Нөхөн сэргээлтийн ажлыг хууль тогтоомжид заасны дагуу хүлээж авч, акт үйлдэж баталгаажуулан, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ